



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 327

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө худалдах, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 9 нэрийн нийт 333,248.41 (гурван зуун гучин гурван мянга хоёр зуун дөчин найман ам.доллар дөчин нэгэн цент) ам.долларын балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар тогтоосугай.

2.Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайд, Ерөнхий консул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгө худалдсанаас олох орлогыг зохих журмын дагуу байгууллагынхаа дансанд төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001492

16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 06 дугаар сарын 15 ны өдрийн
327 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСААС ГАДААД УЛСАД СУУГАА ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРУУДЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСЧ, ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Автомашинь марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуризмтлагдсан элэгдэл (ам.доллар)	Худалдах доод үнэ (ам.доллар)	Байршил (Элчин сайдын яам)
1	Mercedes бенз S350 (RBA-221057) дугаар RYO-1100, Арлын дугаар WDD2210572A527072	2013/2013	66320	25,956.50	1,000.00	Осака хот дахь Монгол Улсын Ерөнхий консулын газар
2	Mercedes бенз E220, арлын дугаар WDD2120111B241233, НҮУW439 дугаартай	8/3/2015	116979	32,780.74	1,500.00	Стокгольм хот дахь Монгол Улсын Элчин сайдын яам
3	WOLKESWAGON Carrevella микробус, дизел WV2ZZZ7HZ8N1336787, 06 CD 1462	1/1/2008	232316	39,113.15	1,500.00	Анкара хот дахь Монгол Улсын Элчин сайдын яам
4	Mercedes Benz S350 BT, WD-744 дугаартай, WDD2220321A018829	2013.11.08	177934	77,138.94	2,000.00	Вена хот дахь Монгол Улсын Элчин сайдын яам
5	Mercedes Benz 200E маркын WDD2120341B135177 арлын дугаартай суудлын автомашин, E0007 дугаартай	2014	145000	25,956.00	1,000.00	Манжуур хот дахь Монгол Улсын Консулын газар

№	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (ам.доллар)	Худалдах доод үнэ (ам.доллар)	Байшил (Элчин сайдын яам)
6	Lexus ES350 маркийн автомашин, F15-18 дугаартай, Арлын дугаар - JTHBK1GG702064969	2013/2013	93500	54,478.60	1,500.00	Тайбэй дахь Улаанбаатар худалдаа, эдийн засгийн төлөөлөгчийн газар
7	Sonata Hybrid маркийн суудлын автомашин 075-012 дугаартай, Арлын дугаар KMHEA415BEA086627	2013.07.20	148325	24,915.84	500.00	Сөүл хот дахь Монгол Улсын Элчин сайдын яам
8	Grandeur HG маркийн суудлын автомашин 075-002 дугаартай, Арлын дугаар KMHFF41CBDA272911	2013.04.01	142171	20,003.64	500.00	Сөүл хот дахь Монгол Улсын Элчин сайдын яам
9	Суудлын автомашин "Mercedes Benz" E200, арлын дугаар WDD2120341B130451, 80-381-NG-01 дугаартай	2015.06.01	27436	32,905.00	1,500.00	Ханой хот дахь Монгол Улсын Элчин сайдын яам
	НИЙТ ДҮН			333,248.41 (гурван зуун гучин гурван мянга хоёр зуун дөчин найман ам.доллар дөчин нэгэн цент)	11,000.00 (арван нэгэн мянга)	